



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Г Журамд өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.7}, Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн, 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалтад доор дурдсанаар өөрчлөлт оруулсугай:

1/ 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн 2.3.1 дэх заалт:


2.4.1. И₃ нь дараах хэмжээтэй байна:

Даатгалын баталгаанд дурдсан жолоочийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлага	И ₃
25 хүртэлх насны, 3 жил хүртэлх туршлагатай	1.2
25 хүртэлх насны, 3 жилээс дээш туршлагатай	1.15
25-оос дээш насны, 3 жил хүртэлх туршлагатай	1.1
25-оос дээш насны, 3 жилээс дээш туршлагатай	1.0

2. Журамд оруулсан өөрчлөлтийг 2015 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Албан журмын даатгагчдын холбоо /Б.Нямдорж/-нд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын өөрчлөлтийг “Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д тусгаж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай



3.НАРАНТУЯА

000928